



ДОРНОГОВЬ АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХЭТИЙН ЗОРИЛТЫН БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ

АГУУЛГА

1. Дорноговь аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг боловсруулах шаардлага, үндэслэл	2
2. Дорноговь аймгийн хөгжлийн хэтийн зорилт	3
2.1 Дорноговь аймгийн алсын хараа	3
2.2 Эрхэм зорилго	3
2.3 Стратегийн зорилт	3
3. Стратегийн зорилт, хэрэгжүүлэх арга зам	4
4. Аймгийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилт	5
5. Хэрэгжүүлэх механизм, хяналт үнэлгээ	5
6. Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн	6
6.1 Шалгуур үзүүлэлт	6
6.2 Хүрэх үр дүн	6
7. Дорноговь аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	8

1. Дорноговь аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг боловсруулах шаардлага, үндэслэл

1.1. Хөгжлийн хандлага

2012 онд Нэгдсэн үндэстний байгууллагын тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтаар дэлхий нийтийн байгаль орчин, нийгэм болон эдийн засгийн тогтолцоонд тулгамдаад байгаа дээрх асуудлыг хэлэлцэж, улмаар улс орон бүр бүс нутаг болон үндэстний тогтолцооны онцлогыг харгалзан ногоон эдийн засгийг дэмжих замаар эдийн засгийн хөгжлийн загварыг өөрчлөх шаардлагатайг онцолсон байдаг. Мөн дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн зорилгыг 2015 оноос 2030 хооронд хэрэгжүүлэхээр хэлэлцэн баталсан.

Монгол улс олон улсын өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал баримт бичгийг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн УИХ-ын тогтоолоор, Монгол улсын "Ногоон хөгжлийн бодлого"-ыг 2014 оны 06 сарын 13 өдрийн УИХ-ын 43-р тогтоол, "Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн УИХ-ын тогтоолоор тус тус баталж хэрэгжилүүлж байна. Мөн 2003 онд УИХ-аар Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн тэнцлийг хангах үүднээс эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалттай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад зорилготой "бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль"-ийг батлан гаргасан байдаг. Улмаар "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай" хуулийг 2015 оны 11 дүгээр сарын 26-ний өдрийн УИХ-ын тогтоол, "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ыг 2016 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн тогтоолоор тус тус баталсан байна. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал баримт бичгийг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн УИХ-ын тогтоолоор баталсан байна.

Иймд дээрх хөгжлийн чиг хандлага болон Монгол улсын өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, эрхзүйн орчны хүрээнд нийцүүлэн тус аймаг нь хөгжлийн хэтийн зорилтыг боловсруулах шаардлагатай байна.

1.2. Дорноговь аймгийн хөгжлийн боломж, сорилт

Дорноговь аймаг нь нийт 109.4 мянган км² нутаг дэвсгэртэй бөгөөд дэд бүтэц сайн хөгжсөнөөс гадна Монгол улсын эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий Замын-Үүд хилийн боомтыг түшиглэн эдийн засгийн гадаад харилцаагаа нэмэгдүүлэх, транзит тээвэрийг нэмэгдүүлэн гадаад, дотоод худалдааны эргэлтийг хөгжүүлэх, мөн орон нутгийн түүх түүх соёлын дурсгалт газруудыг менежментийн сайжруулах замаар дотоодын болон хил орчмын аялал жуулчлалын сүлжээг өргөтгөх замаар тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгалийн нөөц баялагт түшиглэсэн уул уурхай, газрын тосны зэрэгт салбарт дэвшилтэд технологит суурилсан боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх боломжтой байна.

Дорноговь аймаг нь эдийн засгийн бүтэц, дотоотын нийт бүтээгдэхүүнд үйлчилгээний салбар олон жилийн дунджаар 48.3 хувь, Хөдөө аж ахуйн салбар 31.9 хувь, Аж үйлдвэр, барилгын салбар 19.8 хувийг тус тус эзэлж байна. Мөн цаашид уул уулхайн салбар эрчимтэй хөгжих хандлагатай байгаа тулд бодлогын түвшинд уул уурхай болон Хөдөө аж ахуйн хосолсон хөгжлийн бодлогыг хөгжүүлэх замаар Хөдөө аж ахуйн салбарыг урт хугацааны тогтвортой байдлыг хангах нь ихээхэн чухал байна. Хөдөө аж ахуйн салбарт газар тариалангийн үйлдвэрлэл болон бэлчээрийн мал аж ахуй эрхлэн амьдарч байгаа иргэдийн суурьшлийн **хэлбэрээр** (тоог оруулах) шалтгаалан хүн амын амьдралын түвшин, амьжиргаа нь экологийн доройтол, байгалийн гамшигт үзэгдэл (ган, зуд), цаашлаад уур амьсгалын өөрчлөлтөд

өртөмтгий буюу байгалиас хараат, аймгийн түвшинд ядуурлын үндсэн үзүүлэлтээр төвийн бүсийн аймгуудын дундаж үзүүлэлтээс бага, нөгөө талаас ажилгүйдэлийн түвшин буурч байгааг хэдий ч бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо нэмэгдэх хандлагатай, тухайлбал 25-34 насны бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо ихээхэн нэмэгдэж байгаа нь цаашид ядуурлын үндсэн үзүүлэлтүүд нэмэгдэх байдал зэрэг нь томоохон сорилт, бэрхшээл болж байна.

Иймд дээрх хөгжлийн боломжуудыг нэмэгдүүлэх, сорилтуудыг гэтлэн давахад ногоон хөгжлийн шийдлүүдийг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох замаар нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогын уялдаа холбоог сайжруулах засаглалын оновчтой тодорхойлох хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

2. Дорноговь аймгийн хөгжлийн хэтийн зорилт

2.1 Дорноговь аймгийн алсын хараа

/тодорхойлох/:

2.2 Эрхэм зорилго

Экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан, иргэн бүр нь тогтвортой хөгжлийн боловсролтой, эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай, амьжиргааны түвшин өндөр, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвараар тэргүүлэгч аймаг болно.

2.3 Стратегийн зорилт

Дорноговь аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг хангахад дараах стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ

1. Байгаль орчны тогтвортой хөгжил

- Стратегийн зорилт 1.1. Байгалийн нөөц баялгийг зөв зохистой ашиглаж, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн, орчны бохирдол, доройтлыг бууруулна.
- Стратегийн зорилт 1.2 Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжийг нэмэгдүүлж, экосистемийн тэнцвэрт байдал, биологийн олон янз байдлыг хамгаална.

2. Нийгмийн тогтвортой хөгжил

- Стратегийн зорилт 2.1. Хүн амын хөдөлмөр эрхлэлт, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурал, нийгмийн эмзэг байдлыг бууруулж, амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.
- Стратегийн зорилт 2.2. Иргэн бүрийн тогтвортой хөгжлийн боловсролыг дээшлүүлж, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.

3. Эдийн засгийн тогтвортой хөгжил

- Стратегийн зорилт 3.1. Байгаль орчинд сөрөг нөлөөгүй экспортын чиг баримжаатай үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж, хариуцлагатай уул уурхай, тогтвортой хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ.
- Стратегийн зорилт 3.2. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

4. Тогтвортой хөгжлийн засаглал

- Стратегийн зорилт 4.1. Хууль ёсыг эрхэмлэсэн, иргэдэд хүртээмжтэй, ил тод, хариуцлагатай, иргэдийн оролцоог бүх шатанд хангасан нэгдмэл бодлоготой сайн засаглалыг бэхжүүлнэ.

3. Стратегийн зорилт, хэрэгжүүлэх арга зам

Байгалийн нөөц баялгийг зөв зохистой ашиглаж, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн, орчны бохирдол, доройтлыг бууруулах 1.1 дүгээр стратегийн зорилтыг дараах арга замаар хэрэгжүүлнэ:

- Үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорх усны нөөцийн ашиглалтын үр ашиг, хамгаалалтыг сайжруулан, усыг дахин ашиглах дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.
- Уул уурхайн нөлөөгөөр эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг эрчимжүүлж, үйлдвэржилтээс үүдэлтэй орчны бохирдол, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгоно.
- Томоохон сум, суурин газрын хүрээлэн байгаа орчны бохирдлыг бууруулах олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжийг нэмэгдүүлж, экосистемийн тэнцвэрт байдал, биологийн олон янз байдлыг хамгаалах 1.2 дугаар стратегийн зорилтыг дараах арга замаар хэрэгжүүлнэ:

- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжийг нэмэгдүүлнэ.
- Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хамгаалж, нутаг дэвсгэрийн 25-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авна.
- Биологийн олон янз байдлыг хамгаалах, зохистой ашиглах асуудлыг уул уурхай, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр зэрэг салбарын бодлоготой уялдуулж, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

Хүн амын хөдөлмөр эрхлэлт, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурал, нийгмийн эмзэг байдлыг бууруулж, амьжиргааны түвшинг дээшлүүлэх 2.1 дүгээр стратегийн зорилтыг дараах арга замаар хэрэгжүүлнэ:

- Хүн амын дундаж орлогыг үе шаттайгаар нэмэгдүүлэн, ядуурлыг бууруулна.
- Хүрээлэн байгаа орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлтийн хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг бууруулах замаар иргэн бүрийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

Иргэн бүрийн тогтвортой хөгжлийн боловсролыг дээшлүүлж, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх 2.2 дугаар стратегийн зорилтыг дараах арга замаар хэрэгжүүлнэ:

- Байгальд зохицсон ахуй, соёлын үнэт зүйлс, амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг тэгш, хүртээмжтэй, хэнийг ч орхигдуулахгүй олгоно.
- Байгаль орчин, нийгэм соёл, эдийн засгийн тогтвортой хөгжлийн мэдлэгийг олгож, чадварт суурилсан хандлагыг бий болгоно.

Байгаль орчинд сөрөг нөлөөгүй экспортын чиг баримжаатай үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, тогтвортой хөдөө аж ахуй, уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл,

аялал жуулчлалыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх стратегийн 3.1 дүгээр стратегийн зорилтыг дараах арга замаар хэрэгжүүлнэ:

- Газар ашиглалт, дэд бүтэц, барилгажилтын бүсчлэлийн төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлж, хариуцлагын тогтолцоог сайжруулна.
- Хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, нөөцийн үр ашигтай, инновацид суурилсан импортыг орлох үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангана.
- Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, хил орчмын аялал жуулчлалын сүлжээг өргөтгөн, аяллын нэр төрлийг нэмэгдүүлнэ.

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх стратегийн 3.2 дугаар стратегийн зорилтыг дараах арга замаар хэрэгжүүлнэ:

- Олон улсын худалдааны гэрээ, хэлэлцээрт ногоон эдийн засгийн зарчмыг тусган, хүлэмжийн хийн ялгарал багатай, нөөцийн үр ашигтай, эрчим хүчний хэмнэлттэй техник, технологийг дэмжсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Орон нутгийн төсвийн худалдан авалтын 20-иос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил үйлчилгээг худалдан авахад зарцуулна.
- Байгалийн нөөц (ус, эрчим хүч, газар гэх мэт)-ийн ашиглалтын үр ашиг, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлнэ.
- Төсвийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан ил тод нээлттэй төлөвлөн хуваарилж, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж төсөв санхүүгийн зөв зохистой бодлогыг баримтална.

Хууль ёсыг эрхэмлэсэн, иргэдэд хүртээмжтэй, ил тод, хариуцлагатай, иргэдийн оролцоог бүх шатанд хангасан нэгдмэл бодлоготой сайн засаглалыг бэхжүүлэх 4.1 дүгээр стратегийн зорилтыг дараах арга замаар хэрэгжүүлнэ:

- Төр хувийн хэвшлийн түншлэл, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих замаар иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- Төрийн байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлж, чадварлаг боловсон хүчнийг дэмжих бодлогоор төрийн албыг бэхжүүлж, хариуцлагатай, шударга, ил тод байдлыг хангана.

4. Аймгийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилт

Хэрэгжүүлэх үе шат: Дорноговь аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг 2 үндсэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

- 1 дүгээр үе шат: 2018-2021 он;
- 2 дугаар үе шат: 2022-2025 он.

5. Хэрэгжүүлэх механизм, хяналт үнэлгээ

- Хөгжлийн хэтийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Дорноговь аймгийн ИТХ-аар батална.
- Баталсан үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.
- Орон нутгийн бүх шатны сонгуульд оролцох мөрийн хөтөлбөртөө тус хөгжлийн хэтийн зорилтыг хэрэгжүүлэх арга замыг тусган хэрэгжүүлнэ.
- Хөгжлийн хэтийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн идэвх оролцоог тэгш хангана.
- Хөгжлийн хэтийн зорилтыг хэрэгжилтийн үр дүнг Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн үнэлгээ хийнэ.

6. Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн

6.1 Шалгуур үзүүлэлт

Дорноговь аймгийн хөгжлийн хэтийн зорилтын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тогтоож, 2017 оны тоон мэдээллийг суурь болгон авч үзнэ:

№	Үзүүлэлт	2017	2021	2025
Байгаль орчны үзүүлэлт				
1	Хот, суурин газрын ногоон байгууламжийн талбайн нийт хот, тосгон бусад суурин газрын талбайд эзлэх хувь	2.0	3.0	4.0
	Дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээ, тонн	114	350	700
	Боловсруулах үйлдвэрлэлийн хаягдал усан дахь стандартын шаардлагад нийцэх хүртэл түвшинд цэвэрлэсэн хаягдал усны эзлэх хувь	0.0	50.0	80.0
	Уул уурхайн нөлөөгөөр эвдэрсэн газар дахь нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувь	10.4	15	25
	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, сая төгрөгөөр	39.8	50	60
	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөтэй сумдын тоо	2	7	14
	Аймгийн нутаг дэвсгэр дэх тусгай хамгаалалттай газрын эзлэх хувь	12.6	17.0	25.0
Нийгмийн үзүүлэлт				
	Ядуурлын хамралт, хувь	23,2	22.0	20.0
	Ажилгүйдлийн түвшин, хувь	4.3	4.0	3.5
	Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь			
	Ногоон ажлын байрны тоо	4800	5300	5800
	<i>Халдварт өвчнөөр өвчлөгсдийн түвшин</i>	276.0	258.3	206.6

Эдийн засгийн үзүүлэлт				
	Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	35.3	37.5	39.0
	Төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд нийлүүлэх сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрийн өсөлт /мВт/	-	85 мВт	120 мВт
	Нэг хүнд ногдох ДНБ-ний өсөлтийн хувь /2016 онд 3.8 сая төгрөг/	5.0	5.0	5.0
	Байгаль орчны удирдлагын ISO14001-ийг нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийн тоо	0	10	15
	Хувийн хэвшил, банк санхүүгийн салбарын ногоон хөрөнгө оруулалтын хэмжээ			
	Ногоон болон тогтвортой хөгжлийг дэмжсэн худалдан авалтын аймгийн нийт худалдан авалт /мян.төг/			
	Татварын орлого нэмэгдсэн байна. /сая төгрөг/	18995.5	19652.0	20252.0
	Төсвийн зардал хэмнэгдсэн байна /хувь/	3.5	5.0	5.0
	Шилэн дансны хэрэгжилтийн хувь	93.1	100	100
Засаглалын үзүүлэлт /Мянганы хөгжлийн зорилтоос авах/				
	Төсөв, түүний зарцуулалтын тайланг вэб хуудсандаа тогтмол байрлуулдаг төрийн байгууллагын тоо	170	170	170
	Улсын төсвийн төслийг боловсруулах, батлах үед саналаа албан ёсоор ирүүлсэн иргэний нийгмийн байгууллагын тоо	0	2	2

6.2 Хүрэх үр дүн

1 дүгээр үе шат: 2018-2021 он

Дорноговь аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг хангахад чиглэсэн салбар хоорондын уйлдааг холбоог хангах засаглалын оновчтой хувилбарыг бүрдүүлж, салбарын дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.

2 дугаар үе шат: 2022-2025 он

7. Дорноговь аймгийн хөгжлийн хэтийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Дорноговь аймгийн хөгжлийн хэтийн зорилтын дараах үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд хэрэгжилтүүлнэ.

Аймгийг хөгжүүлэх хэтийн зорилтын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө

Арга зам	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага	Хэрэгжих хугацаа	Санхүүжилтийн эх үүсвэр*	Хүрэх үр дүн
1. Байгаль орчны тогтвортой хөгжил						
Зорилт 1.1. Стратегийн зорилт 1.1. Байгалийн нөөц баялгийг зөв зохистой ашиглаж, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн, орчны бохирдол, доройтлыг бууруулна.						
Үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорх усны нөөцийн ашиглалтын үр ашиг, хамгаалалтыг сайжруулан, усыг дахин ашиглах дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.	Газар доорх усны нөөц нь батлагдсан ордыг ус хангамжид ашиглан, усны нөөц, ус ашиглалтын байдалд тавих хяналтыг сайжруулна	ААНБ	МХГ, БОАЖГ, Сав газрууд, аймаг, сумын Засаг дарга	2018-2026	ААНБ-ын хөрөнгийн эх үүсвэр	
	Стандартын шаардлага хангахгүй уст цэгүүдэд ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулна	Аймаг, Сумын Засаг дарга, БОАЖГ	МХГ, БОАЖГ, Сав газрууд, Аймаг, Сумын Засаг дарга	2018-2026	Аймаг, орон нутгийн төсөв	
	Рашаан төст булгуудыг шинжилгээнд хамруулж, булаг шандын энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, бохирдлоос хамгаална	Сумдын Засаг дарга	Сав газрын захиргаа, БОАЖГ, ААН	2018-2022	СОНТ	
	Гэр хорооллын айл өрхийг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ	Аймаг, сумын Засаг дарга	“Чандмань-Илч” ХХК, “Чандмань бадрал” ХХК	2018-2026	УТ, ОНТ, төсөл	
Уул уурхайн нөлөөгөөр эвдэрсэн газрын нөхөн сэргээх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ	Эвдэрсэн газар, уул уурхайн дүйцүүлэн хамгаалах газрын судалгааг нарийвчлан гаргаж нөхөн сэргээх, хамгаалах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ	ААНБ	МХГ, БОАЖГ, аймаг, сумын Засаг дарга	2018-2026	ААНБ-ын хөрөнгийн эх үүсвэр	
	Хог хаягдлын менежментэд төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг өргөнөөр ашиглаж, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулаж эрчим хүч гаргах, бордоо, зам талбай, барилгын материал үйлдвэрлэх үйл ажиллагааг дэмжинэ	ААНБ	МХГ, БОАЖГ, ГХБХБГ, аймаг, Сумын Засаг дарга	2018-2026	ААНБ-ын хөрөнгийн эх үүсвэр	

	Аюултай хог хаягдлыг устгах, түр хадгалах зориулалтын байгууламжийг байгуулж, аюултай хог хаягдлын тархалтыг багасгах чадавхийг бүрдүүлнэ	ЭМГ	АЗДТГ, Сумдын Засаг дарга	2019-2021	ОНТ, төсөл хөтөлбөр	
Томоохон сум, суурин газрын хүрээлэн байгаа орчны бохирдлыг бууруулах олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Гэр хорооллын айл өрхийн цахилгаан халаагуур ашиглах техникийн боломжийг бүрдүүлэх, стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах зэргээр түүхий нүүрсний хэрэглээг багасгана	Сумдын Засаг дарга	АЗДТГ, БОАЖГ, ААНБ	2019-2022	ОНТ, төсөл хөтөлбөр	
	Гэр хорооллын ногоон бүс, бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулан, нэг хүнд ногдох цэцэрлэгжсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх замаар орчны бохирдлыг бууруулна	Сумдын Засаг дарга	БОАЖГ, Олон улсын байгууллага, ТББ	2018-2026	СОНТ, УТ, төсөл хөтөлбөр	
Стратегийн зорилт 1.2 Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжийг нэмэгдүүлж, экосистемийн тэнцвэрт байдал, биологийн олон янз байдлыг хамгаална.						
Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжийг нэмэгдүүлнэ.	Олон нийтэд уур амьсгалын өөрчлөлтийн тухай мэдээллийг өгөх, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагаа, арга хэмжээнд идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлнэ	Аймаг, сумын Засаг дарга	БОАЖГ, ТББ, иргэний нийгмийн байгууллага	2018-2026	УТ, ОНТ, төсөл хөтөлбөр	
	Байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэл, хэрэглээний үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх замаар хүлэмжийн хийн ялгаралтыг үе шаттайгаар бууруулна	Аймаг, сумын Засаг дарга	БОАЖГ, ТББ, иргэний нийгмийн байгууллага	2018-2026	УТ, ОНТ, төсөл хөтөлбөр	
	Аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл, төрийн бус байгууллага, иргэдийн ногоон үйлдвэрлэл эрхлэх, түүний хэрэглээг нэмэгдүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх зэргээр уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг	Аймаг, сумын Засаг дарга	БОАЖГ, ТББ, иргэний нийгмийн байгууллага	2018-2026	УТ, ОНТ, төсөл хөтөлбөр	

	дэмжинэ					
Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хамгаалж, нутаг дэвсгэрийн 25-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авна.	Газрын доорх усны нөөц, тэжээгдлийн муж, байгалийн бусад нөөц, дурсгалт газрыг тусгай хамгаалалтанд авна	Аймаг, Сумын Засаг дарга, СГЗахираа	БОАЖГ	2018-2026	УТ, Аймаг, орон нутгийн төсөв	
	Тусгай хамгаалалттай газрын бүртгэлийг сайжруулж, уул уурхайн тусгай зөвшөөрлийн талбайн давхцлыг арилгана	АЗДТГ	БОАЖГ, ГХБХБГ, сумдын Засаг дарга	2018-2026	ОНТ, СОНТ, БХНС сан	
Биологийн олон янз байдлыг хамгаалах, зохистой ашиглах асуудлыг уул уурхай, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр зэрэг салбарын бодлоготой уялдуулж, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийг эрчимжүүлнэ.	Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өвөрмөц экосистемийг бүхэлд нь тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулж, менежментийг нь сайжруулна	БОАЖГ	АЗДТГ, ГХБХБГ, сумдын Засаг дарга	2018-2026	УТ, ОНТ, БХС	
	Төр, нутгийн иргэд, хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох замаар байгалийн нөөц, ялангуяа агнуурын амьтны нөөцийн зохистой ашиглах, хамгааллын менежментийг сайжруулна	БОАЖГ	Аймаг, сумын Засаг дарга, ТББ, иргэдийн бүлэг, нөхөрлөл	2018-2026	СОНТ, БХС	
	Хөдөө аж ахуй, эрдэс баялаг, дэд бүтэц, эрчим хүч, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудаас биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж байгаа болон нөлөөлөх магадлалтай үйл ажиллагааг бууруулна	БОАЖГ	Аймаг, сумын Засаг дарга, ТББ, иргэдийн бүлэг, нөхөрлөл	2018-2026	ОНТ, СОНТ, БХС	
2. Нийгмийн тогтвортой хөгжил						
Стратегийн зорилт 2.1 Хүн амын хөдөлмөр эрхлэлт, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурал, нийгмийн эмзэг байдлыг бууруулж, амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.						

Хүн амын дундаж орлогыг үе шаттайгаар нэмэгдүүлэн, ядуурлыг бууруулна.	Нийгмийн бүлгийн амьжиргааг дэмжих, ядуурлыг бууруулах, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;	ХХҮГ	Аймаг, сумын Засаг дарга	2018-2026	ОНТ, СОНТ, төсөл хөтөлбөр	
Хүрээлэн байгаа орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлтийн хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг бууруулах замаар иргэн бүрийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.	байгальд ээлтэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, үр ашигтай, дэвшилтэт технологи бүхий барилгын материалын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих	Аймаг, сумын Засаг дарга	ГХБХБГ, ААН	2018-2026	УТ, ОНТ, төсөл хөтөлбөр	
Стратегийн зорилт 2.2 Иргэн бүрийн тогтвортой хөгжлийн боловсролыг дээшлүүлж, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.						
Байгальд зохицсон ахуй, соёлын үнэт зүйлс, амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг тэгш, хүртээмжтэй, хэнийг ч орхигдуулахгүй олгоно.	Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн хөгжлийн тухай хичээлийг бүх шатны сургуулийн сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ	БСГ	АЗДТГ, УЦУОШГ, БОАЖГ	2018-2026	ОНТ, төсөл хөтөлбөр	
	Байгаль, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн мэдээллийг ашиглах, авран хамгаалах талаар сургалт, семинар, сурталчилгааны ажил тогтмол явуулна	ОБГ, УЦУОШГ	БОАЖГ	2018-2026	ОНТ, төсөл хөтөлбөр	
Байгаль орчин, нийгэм соёл, эдийн засгийн тогтвортой хөгжлийн мэдлэгийг олгож, чадварт суурилсан хандлагыг бий						

болгоно.						
Стратегийн зорилт 2.3 Хүн амыг өвчнөөс сэргийлэх мэдлэг дадал хандлагад төлөвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөлийг бууруулж, дундаж наслалтыг уртасгана.						
2.3.1. Эрүүл мэндийн байгууллагуудын дэд бүтэцийг сайжруулж, оношилгоо, эмчилгээний чадамж, хүртээмжийг дээшлүүлнэ	<p>2.3.1.1. Нэгдсэн эмнэлгүүдийн оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжийн хангалтыг шат дараатай нэмэгдүүлж, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, Цахим эрүүл мэнд төслийг хэрэгжүүлж, Smart Hospital болгох, телемедициний нэгдсэн сүлжээнд холбоно</p> <p>2.3.1.2. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дэд бүтцийг сайжруулж ээлтэй орчин бүрдүүлэх, зайлшгүй шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх замаар иргэдэд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна</p> <p>2.3.1.3. Халдварт, Хүүхдийн эмнэлэг, “Талст зам” өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг тус тус шинээр барьж, Замын-Үүд сумын болон аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх эмнэлгийн барилгуудыг ашиглалтанд хүлээн авч Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх тав тухтай орчинг бүрдүүлэх</p>	Эрүүл мэндийн газар	ЭМЯ, бүх шатны Засаг дарга, ЗДТГ, нэгдсэн эмнэлгүүд, сум өрхийн эрүүл мэндийн төвүүд, ГХБХБГ, цахилгаан шугам сүлжээ, Чандмана илч ХХК		Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хандив тусламж	<ul style="list-style-type: none"> • Хоёрдох шатлалын эмнэлгүүд цахим эмнэлэг болж, үйлчлүүлэгч дийн мэдээллийн сантай болох, тусламж үйлчилгээн ий чанар сайжирч хүлээгдэл чирэгдэл буурна • Анхан шатны тусламж үйлчилгээн ий чанар хүртээмж нэмэгдэж үйлчлүүлэгч дийн сэтгэл ханамж дээшилнэ • Эмнэлгүүди йн ачаалал буурч халдвар хамгааллын дэглэм сайжирч,

						ээлтэй орчин бүрдэнэ
2.3.2. Төр, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн хамтын ажиллагааг уялдуулан өргөжүүлж, хувийн эмнэлгүүдийн хөгжлийг дэмжин чадавхжуулна	2.3.1.1. Орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник технологи бүхий хувийн хэвшлийн эмнэлгүүдийг дэмжиж, шинжилгээ оношилгоог харилцан хүлээн зөвшөөрдөг болгох, нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, дэмжлэг удирдлагаар хангах 2.3.1.2. Хувийн хэвшлийн эмнэлгүүдийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх зардлын хэмжээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, иргэнд учрах төлбөрийн дарамтыг бууруулна.	Эрүүл мэндийн газар	ЭМЯ, ЗДТГ, нэгдсэн эмнэлгүүд, сум өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд		Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хандив тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө	<ul style="list-style-type: none"> Төр хувийн хэвшлийн түгшлэл сайжирч төрийн эрүүл мэндийн байгууллагуудын ачаалал буурч, тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн санхүүжилтийн тогтолцоо боловсронгуй болж иргэдэд учрах эдийн засгийн дарамт буурна
2.3.3. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд байгууллага, иргэдийн оролцоог идэвхжүүлж,	2.3.3.1. Аймгийн Эрүүл мэндийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхижүүлж, салбар хоорондын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурлан “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Эрүүл ирээдүй-Дорноговь” зэрэг нийгмийн	Эрүүл мэндийн газар	ЭМЯ, бүх шатны Засаг дарга, ЗДТГ, нэгдсэн эмнэлгүүд, сум өрхийн		Улсын болон орон нутгийн	<ul style="list-style-type: none"> Нийгмийн эрүүл эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж,

<p>үйлчлүүлэгчдэд ээлтэй, эрүүл мэндийн дэмжлэгт орчинг бүрдүүлнэ.</p>	<p>эрүүл мэндийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж иргэдийн эрүүл аж төрөх мэдлэг дадлыг төлөвшүүлэх. 2.3.3.2."Халдварт өвчнөөс сэргийлэх хянах", "Орчны эрүүл мэнд" дэд хөтөлбөрүүдийг орон нутгийн бодлого, хөгжилтэй уялдуулан хэрэгжүүлж иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх 2.3.3.3. Говийн хүн амын дунд түгээмэл тохиолдож буй хоол боловсруулах замын өвчлөлийг бууруулах чиглэлээр ундны усны аюулгүй байдал, баталгаат хүнсний бүтээгдэхүүний талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлнэ. 2.3.3.4. Уламжлалт Анагаах ухаан, рашаан сувиллын төв, БНХАУ-ын Олон Улсын Монгол эмнэлгийн хамтын ажиллагааг өргөжүүлж, сэргээн засах тусламж үйлчилгээг өргөжүүлж, Эрдэнэ сумын нутаг дахь "Цагаан худаг"-ийн рашааныг эрүүл мэндийн чиглэлээр ашиглах боломжийг судалж,"Бүрдэнэ булаг" "Халзан уул" рашаан сувиллыг дагасан аялал жуулчлал, эрүүл мэндийн цогц үйлчилгээг нэвтрүүлэх 2.3.3.5. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийг жилд нэг удаа эрүүл мэндийн иж бүрэн үзлэг оношилгоонд хамруулж, "Явуулын амбулатори", шүдний үзлэгийг өргөжүүлж, "Эрүүл шүд" аяныг өрнүүлэх замаар хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах</p>		<p>эрүүл мэндийн төвүүд, БСУГ, БОАЖГ, МХГ, ГБХЗХТ , ХХҮГ, ЦГ, ОБГ</p>		<p>төсвийн хөрөнгө оруулалт , хандив тусламж</p>	<p>салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирна</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүл аюулгүй орчин бүрдэж халдварт өвчний тархалт буурна • Ундны усны чанар аюулгүй байдал сайжирч хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт сайжирна • Уламжлалт анагаах ухаан сэргээн засах тусламж үйлчилгээн ий хүртээмж чанар дээшилж эрүүл мэнд аялал
--	---	--	---	--	--	--

						<p>жуулчлал хөгжинө</p> <ul style="list-style-type: none"> Алслагдсан хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн хүртээмж нэмэгдэж, хүүхэд өсвөр үеийнхний амны хөндийн эрүүл мэндийн үзүүлэлт сайжирна
<p>2.3.4. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ</p>	<p>2.3.4.1. Аймгийн Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулан эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг чадвар, ёс зүй, харилцаа хандлага, ажлын хариуцлагыг дээшлүүлж, хөдөө орон нутгийн эмч, мэргэжилтнүүдийг орон сууцаар хангах, урамшуулал олгох орон нутгийн дэмжлэгт орчинг бүрдүүлнэ</p> <p>2.3.4.2. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг өндөр хөгжилтэй улс орон болон дотоодын урт, богино хугацааны сургалтанд хамруулж, гадаадын эмч мэргэжилтнүүдийн сайн туршлагыг нэвтрүүлэх, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч мэргэжилтний хангалтыг нэмэгдүүлэх</p>	<p>Эрүүл мэндийн газар</p>	<p>ЭМЯ, бүх шатны Засаг дарга, ЗДТГ, нэгдсэн эмнэлгүүд, сум өрхийн эрүүл мэндийн төвүүд</p>		<p>Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хандив тусламж</p>	<ul style="list-style-type: none"> Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогын баримт бичиг батлагдаж, хүний нөөцийн ёс зүй хариуцлага дээшилж, нийгмийн баталгаа сайжирна

						<ul style="list-style-type: none"> Орон нутгийн Эрүүл мэндийн байгууллагын удын хүний нөөцийн хангамж нэмэгдэж, төрөлжсөн нарийн мэргэжлийн өндөр мэдлэг ур чадвартай эмч эмнэлгийн мэргэжилтний тоо нэмэгдэнэ
--	--	--	--	--	--	---

3. Эдийн засгийн тогтвортой хөгжил

Стратегийн зорилт 3.1. Стратегийн зорилт 3.1 Байгаль орчинд сөрөг нөлөөгүй экспортын чиг баримжаатай үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, тогтвортой хөдөө аж ахуй, уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ.

Газар ашиглалт, дэд бүтэц, барилгажилтын бүсчлэлийн төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлж, хариуцлагын тогтолцоог сайжруулна.						
Хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, нөөцийн үр ашигтай, инновацид	Шинжлэх ухааны ололт дээр суурилсан үйлдвэрлэлийн хог хаягдалыг дахин боловсруулах, байгааль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлыг зохион	ХХААГ	ХОХБТХ Сумдын засаг дарга нар	2030	ОНТ ХХО	Үйлдвэрлэлийн дамжлагаас гарах хаягдалыг эцсийн

<p>суурилсан импортыг орлох үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтыг дэмжинэ.</p>	<p>байгуулах.</p>					<p>бүтээгдэхүүн болгох, байгальд учруулах нөлөөллийг багасгаж эко үйлдвэрлэлийн дамжлагыг нэвтрүүлдэг болох.</p>
	<p>Орон нутгийн онцлог шинж чанар, түүхий эдийн нөөц боломжинд тулгуурлан инновацид суурилсан бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн эдийн засгийн үр өгөөжийг бий болгох.</p>	<p>ХХААГ</p>	<p>ХОХБТХ Сумдын засаг дарга нар</p>	<p>2030</p>	<p>ОНТ ХХО</p>	<p>Орон нутгийн онцлог шинж чанар бүхий нөөцийн үр өгөөжтэй байдлыг дээд зэргээр бий болгож орон нутгийн хэрэглэгчдийн хэрэгцээг импортын баримжаа бүхий бараа бүтээгдэхүүнэр хангах.</p>
<p>Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангана.</p>	<p>Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй технологи нэвтрүүлж орон нутгийн онцлогт тохирсон органик газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлнэ.</p>	<p>ХХААГ</p>	<p>Сумдын ЗДТГ, ТББ,</p>	<p>2018-2025</p>	<p>УТ, ОНТ, ХХО</p>	<p>Аймгийн нийт хүн амын төмс хүнсний ногооны жилийн хэрэгцээний 20%-ийг үйлдвэрлэдэг болсон байна.</p>
	<p>Мал эмнэлгийн лабораторийн орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр нэвтрүүлж, үндэсний тохирлын шаардлага хангасан лабораторийг</p>	<p>ХХААГ</p>	<p>УМЭҮГ, МЭАЦТЛ, АЗДТГ</p>	<p>2018-2021</p>	<p>Ази хөгжлийн банк</p>	<p>Лабораторийн оношилгоо, шинжилгээний чанар сайжирч,</p>

	бий болгох ажлыг шат дараалалтайгаар зохион байгуулах					өвчний гаралт, тархалтыг 1%-иар буурсан байна.
	Уламжлалт мал аж ахуйн ашиг шимийг нэмэгдүүлэх, Бэлчээрийн даацад нийцсэн мал сүргийн тоо төрлийн зохистой харицааг бүрдүүлэх	ХХААГ	АЗДТГ, Сумдын ЗДТГ	2018-2025	ОНХС, СХС,ЖДҮ	Өндөр ашиг шимт малын тоо 2%-иар өссөн байх
	Хүн амын төвлөрсөн зах зээлийн эрэлтийг харгалзан эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж үйлдвэрийн аргаар боловсруулсан мах сүүний хангамжийг нэмэгдүүлнэ.	ХХААГ	АЗДТГ, Сумдын ЗДТГ	2018-2025	ОНХС, СХС,ЖДҮ	Үйлдвэрийн аргаар боловсруулсан Мах сүүний хангамж ... хувиар нэмэгдсэн байх
	Хурайшилттай нөхцөлд зохицсон ус хэмнэх, хөрс хамгаалах технологид тулгуурласан усалгаатай газар тариаланг нэмэгдүүлнэ	ХХААГ	АЗДТГ, Сумдын ЗДТГ	2018-2025	ОНХС, СХС,ЖДҮ	
Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, хил орчмын аялал жуулчлалын сүлжээг өргөтгөн, аяллын нэр төрлийг нэмэгдүүлнэ.	Хот хоорондын авто замын дагуу жуулчдын ая тухыг хангасан ногоон шийдэлтэй түр буудаллах үйлчилгээний төвүүдийг байгуулахыг дэмжинэ	Аймгийн Засаг дарга	БОАЖГ, ГХБХБГ, АЖХ	2018-2026	УТ, ОНТ, төсөл хөтөлбөр	
	Аялал жуулчлалын бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлж, улирлын хамаарлыг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлнэ					
	тусгай хамгаалалттай болон соёлын өвийн бүс нутгуудад аялал жуулчлалыг хөгжүүлнэ					
	Хил дамнасан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, аяллын замналыг бий болгоход хөрш орнуудтай хамтран ажиллана					
Стратегийн зорилт 3.2 Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.						

Олон улсын худалдааны гэрээ, хэлэлцээрт ногоон эдийн засгийн зарчмыг тусган, хүлэмжийн хийн ялгарал багатай, нөөцийн үр ашигтай, эрчим хүчний хэмнэлттэй техник, технологийг дэмжсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	Олон улсын худалдааны гэрээ, хэлэлцээрээр хийх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтад эрчим хүчний хэмнэлттэй технологи бүхий бараа материал, тоног төхөөрөмж ашиглах, ногоон байгууламжийг хамтад нь иж бүрнээр шийдэх ажлыг хэрэгжүүлнэ.	Орон нутгийн удирдлага, Хөрөнгө оруулагч, бэлтгэн нийлүүлэгч	Ашиглагч, худалдан авагч байгуулага	2018-2026	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Олон улсын гэрээгээр гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын хамт ногоон байгууламж нэмэгдсэн байна.
Орон нутгийн төсвийн худалдан авалтын 20-иос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил үйлчилгээг худалдан авахад зарцуулна.	Худалдан авах ажиллагаанд захиалагч болон оролцогч нарын тендер шалгаруулалтад шаардлагатай материалыг хэвлэмэл байдлаар ашигладаг байсныг цахим хэлбэрт шилжүүлэх Тендерийн баримт бичигт байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил үйлчилгээний тухай тодорхой тусгах	ОНӨГ	АЗДТГ, Сумдын Засаг дарга, агентлагууд, ААНБ	2018-2026	ОНТ	Байгаль орчинд ээлтэй, үр ашигтай хэмнэлттэй бараа, ажил үйлчилгээ худалдан авалт 20 хувьд хүрсэн байна
Байгалийн нөөц (ус, эрчим хүч, газар гэх мэт)-ийн ашиглалтын үр ашиг, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлнэ.	Сэргээгдэх эрчим хүчний төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллана. Нарны цахилгаан станц, Салхин цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулахад хамтран ажиллах.	ААНБ	Орон нутгийн удирдлага, Цахилгаан түгээх сүлжээ компани	2018-2026	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Төвийн эрчим хүчний системд нийлүүлэх дотоодын эрчим хүчний хэмжээ өссөн байна.
Төсвийг орон нутгийн хөгжлийн	Татварын далд эдийн засгийг ил болгох зохицуулалтын арга	СТСХ, Татварын	МХГ, Цагдаагийн газар, БОАЖГ, Сав	2018-2026	ОНТ	Орлогын төлөвлөгөө

бодлоготой уялдуулан ил тод нээлттэй төлөвлөн хуваарилж, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж төсөв санхүүгийн зөв зохистой бодлогыг баримтална.	хэрэгслийг ашиглан төсвийн орлогыг бүрдүүлэх, эх үүсвэрийг нэмэгдүүлэнэ.	хэлтэс	газар, Сумын Засаг дарга, УБХ, Авто тээврийн төв, ГХБХБГазар.			биелсэн байна.
	Төсвийн ил тод байдлыг хангаж санхүүгийн сахилга бат, төрийн сангийн дотоод хяналтыг сайжруулан, батлагдсан төсвийн хүрээнд ажиллана.	СТСХ	Сумын Засаг дарга, төсвийн байгууллагууд.	2018-2026	ОНТ	Өр, авлага буурч, төсөв хэмнэгдсэн байна

4. Тогтвортой хөгжлийн засаглал

Стратегийн зорилт 4.1. Хууль ёсыг эрхэмлэсэн, иргэдэд хүртээмжтэй, ил тод, хариуцлагатай, иргэдийн оролцоог бүх шатанд хангасан нэгдмэл бодлоготой сайн засаглалыг бэхжүүлнэ.

Төр хувийн хэвшлийн түншлэл, иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих замаар иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бодлого хэрэгжүүлнэ.	Аймгийн Засаг дарга, Тамгын газар	Сумын Засаг дарга, агентлаг, байгууллагын дарга нар	2018-2026	Орон төсөв нутгийн	Төрийн үйлчилгээний зардал буурч, хүртээмж нэмэгдэнэ.
	Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагаас шийдвэр гаргах явцат иргэний нийгмийн оролцоог хангана.	Аймгийн ИТХ, Засаг дарга	Сумын ИТХ, Засаг дарга, агентлаг, байгууллагын дарга нар	2018-2026	Орон төсөв нутгийн	Иргэдийн эрх ашигт нийцсэн шийдвэр гардаг болно.
	Нутгийн удирдлагын байгууллагууд болон тэдгээрт ажиллаж байгаа албан тушаалтнуудын үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагаас хяналт тавих бололцоо бүрдүүлнэ.	Аймгийн ИТХ, Засаг дарга	Сумын ИТХ, Засаг дарга, агентлаг, байгууллагын дарга нар	2018-2026	Орон төсөв нутгийн	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.
	Шинээр батлагдах хуулийн төслийн хэлэлцүүлэгт иргэний нийгмийн байгууллагыг оролцуулах	Аймгийн ИТХ, Засаг дарга	Сумын ИТХ, Засаг дарга, агентлаг, байгууллагын дарга нар	2018-2026	Орон төсөв нутгийн	Хуулийн төсөл боловсруулахад иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоо хангагдсан байна.
	Төрийн болон орон нутгийн	Аймгийн ИТХ,	Сумын ИТХ, Засаг	2018-2026		Төрийн болон

	хөрөнгөөр бараа, ажл, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж, худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд оролцох иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг нэмэгдүүлнэ.	Засаг дарга	дарга, Орон нутгийн өмчийн газар			орон нутгийн хөрөнгөөр бараа, ажл, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг сайжирч, худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд оролцох иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг нэмэгдэнэ.
Төрийн байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлж, чадварлаг боловсон хүчнийг дэмжих бодлогоор төрийн албыг бэхжүүлж, хариуцлагатай, шударга, ил тод байдлыг хангана.	Орон нутгийн төрийн байгууллагуудад чиг үүрэгтээ тохирсон, үйл ажиллагааны хийдэл давхардалгүй, хамтын манлайллыг хэрэгжүүлэгч бүтэц тогтооно.	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Сумын Засаг дарга, агентлаг, байгууллагын дарга нар	2018-2020	Орон төсөв	нутгийн чанар, хүртээмж нэмэгдэнэ.
	Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалан мэдлэг боловсрол, ёс зүй, туршлага, чадвартай төрийн албыг төлөвшүүлэн тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Сумын Засаг дарга, агентлаг, байгууллагын дарга нар	2018-2020	Орон төсөв	нутгийн чанар, хүртээмж нэмэгдэнэ.
	Салбар хоорондын удирдлагын уялдааг сайжруулах үндсэн дээр хариуцлагатай, шударга, ил тод төрийн албыг бүрдүүлнэ.	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Төрийн албаны салбар зөвлөл, Сумын Засаг дарга, агентлаг, байгууллагын дарга нар	2018-2020	Орон төсөв	нутгийн чанар, хүртээмж нэмэгдэнэ.

*Санхүүжилтийн эх үүсвэр: Улсын болон орон нутгийн төсөв; гадаадын зээл, тусламж; гадаад, дотоодын хөрөнгө оруулалт; Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас; концессын гэрээ; бусад эх үүсвэр гэх мэт.